D. Ходсоны шинж тэмдэг

E. “Швейцарын бяслаг” шинж тэмдэг

/144./ Сүрьеэгийн гонитын рентген онцлог шинжээс ?

A. ясны эпифизын төгсгөлд их биш хэмжээний ясны хальсны өөрчлөлт илэрч, тойг уртасч, өргөсөж, ясны эвдрэлийн өөрчлөлтийн эргэн тойрон остеоосклероз далан (вал) үүсдэг боловч остеопороз илрэхгүй байх

B. тойгны ар гадарга дээр мөгөөрс дор их биш хэмжээний хээ угалз (узур) илрэх боловч ясанд эвдрэлт өөрчлөлтгүй, ясны хальсны өөрчлөлт байхгүй байхад үений зай эрс нарийсч, гол төлөв тойгны хэсэгт анкилоз үүсч, өвчний эхлэл хурдан явцтай болон өвчин ихтэй байх

C. остеопороз, капсул зузаарах болон тэлэгдэх, дугариг эсвэл шаантаг хэлбэрийн, их биш хэмжээний, шүдэлсэн, зах хязгаар жигд бус ясны өөрчлөлт болон секвестр үүсч, энхондраль мөгөөрсөн зон гэмтсэнээс өсөлт алдагдаж, мөчний хэлбэр алдагдах

D. гүн эвдрэлт өөрчлөлтгүй боловч, үений зай нэлээд долгионтож, нарийсах болон хил хязгаар тод жигд байх

E. үений зай нэлээд жигд нарийсч, ясан ургацтай, остеопороз болон анкилозгүй, өвчний явц удаан, үений үйл ажиллагаа хязгаарлагдаж, их биш өвдөлт өгөх

/145./ Гавал тархины өмнөд артерийн инфарктын үед рентген компьютерт томограмм дээр нягтрал буурах зон хаана тодрох вэ ?

A. гавал тархины духны хэсгээр

B. гавал тархины дагзны хэсгээр

C. гавал тархины чамархай хэсгээр

D. гавал тархины суурь хэсгээр

E. гавал тархины зулайн хэсгээр

/146./ Доорх радиофармакологийн аль нь бөөрний түүдгэнцрийн фильтраци тодорхойлоход өргөн хэрэглэгддэг вэ

A. Tc-99m DTPA

B. Tc-99m MAG3

C. I-131 OIH

D. Tc-99m DMSA

E. Tc-99m GH

/147./ Нэвчилтээр жинлэгдсэн дараалалд тархины шигдээс ямар хугацаанд эмгэг дохио өгч эхлэх вэ ?

A. 7-10 цагийн дотор

B. 12-20 цагийн дотор

C. 4-6 цагийн дотор

D. 24 цагаас дээш

E. 3 цагийн дотор

/148./ Уушгины бронх гаднах хавдрын II-р фазын рентген онцлог шинжээс ?

A. бронхын эргэн тойрон 1 см орчим сүүдэржилт тодорхойлогдох боловч уушгины талбайн агааржилт хэвийн

B. хэдэн см хэмжээний сүүдэржилт тодорхойлогдож, уушгины уг өргөсөх

C. хэдэн см хэмжээний сүүдэржилт тодорхойлогдож, дэлбэн эсвэл сегментийн агааржилт ихсэх

D. гурвалжин хэлбэрийн нягтрал жигд бус сүүдэржилт тодрох

E. 1.5 см-ээс том сүүдэржилт тодорхойлогдож, дэлбэн эсвэл сегментийн уушгины зураглал олширох

/149./ КТ-р нойр булчирхайн цочмог үрэвслийн Бальтазарын ангилалаар А зэрэг ямар байх вэ ?

А. нойр булчирхай хэсэг газараа эсвэл тархмал томорсон, хил хязгаар тод-жигд бус, бүтцийн ижил төрөлшил алдагдсан, холимог нягтралтай, нойр булчирхайн эргэн тойрны өөхлөгт үрэвслийн өөрчлөлтгүй

В. нойр булчирхайн цуллагт том биш, ихэнхидээ ганц шингэн агуулсан хэсэг тодорч, хил хязгаар тод бус байна.

С. нойр булчирхайн цуллагт 2 болон түүнээс олон тооны, том хэмжээний шингэн агуулсан хэсэг тодорч, нойр булчирхайн цуллаг эсвэл хэвлийн арын зайнд хийн бөмбөлөг тодорно.

Д. нойр булчирхайн цуллагт өөрчлөлттэй, нойр булчирхайн эргэн тойрны өөхлөгт үрэвслийн өөрчлөлттэй

Е. нойр булчирхай өөрчлөлтгүй

/150./ Т1-ээр жинлэгдсэн дараалалд цочмог цус хуралт ямар дохионы эрчим өгөх вэ ?

А. тод

В. бараан

С. бүцийн ижил төрөлшилтэй

Д. бүтцийн ижил төрөлшил алдагдсан

Е. хил хязгаар тод бус

/151./ Түнхний хэт авиан оношилгоонд шаардлагатай хэт авиа үүсгэгч аль нь вэ ?

А. 2.5 МГц-ийн шугаман хэт авиа үүсгэгч

В. 11 МГц-ийн шугаман хэт авиа үүсгэгч

С. 3.5-5 МГц-ийн конвекс хэт авиа үүсгэгч

Д. 5-7.5 МГц-ийн шугаман хэт авиа үүсгэгч

Е. 7.5 МГц-ийн конвекс хэт авиа үүсгэгч

/152./ Бөөрний ренограммын оргил цэг (Т max) юуг илэрхийлдэг вэ?

А. бөөрний холтослог эдийн оргил шингээлт бөөрний клиренстэй ялгаатай байна

В. экскрецийн эхлэл

С. экскрецийн төгсгөл

Д. бөөрний клиренс эхэлж буйг

Е. бөөрний холтослог эдийн оргил шингээлт бөөрний клиренстэй ижил байна

/153./ Ямар эмгэгийн үед ихэсийн зузаан багасах вэ ?

А. ургийн цус задрах өвчин

В. хорионамнионит

С. чихрийн шижин

Д. плацентит

Е. усан ихэр

/154./ Б.В.Петровский болон Э.Н.Ванцины ангилалаар Ахалазийн II үе шатанд илрэх рентген онцлог шинж тэмдгээс ?

А. улаан хоолойн төгсгөлийн хэсэг үл мэдэг нарийсах боловч (0.5-3 мин), бари ордог. Ходоодны хийн бөмбөлөг, перистальтик хэвийн. Улаан хоолойн уян хатан хэвийн болон өргөсөөгүй.

В. улаан хоолой 5 см хүртэл өргөссөн, уртассан, тахиралдсан, перистальтик байдаггүй, улаан хоолойд өлөн үед салслаг, шингэн, хоолны үлдэгдэл тодорно. Ходоодны хийнбөмбөлөг багасах эсвэл байхгүй болох, улаан хоолойн төгсгөлийн хэсэг нарийсах эсвэл үзүүрлэсэн харандаа, тагтаан хушуу, хулганы сүүл, луув

С. улаан хоолойн хил хязгаар тод-жигд бус, хэлбэр дүрсээ алдсан, улаан хоолойн төгсгөлийн хэсэг хоолой маягаар нарийсах

Д. улаан хоолой 3 см хүртэл өргөсч, эсрэг перистальтик илэрч, улаан хоолойн төгсгөлийн хэсэг нарийсна. Ходоодны хийн бөмбөлөг багасна. Ацетилхолины сорил (+)

Е. улаан хоолой 5 см-ээс их өргөснө. Улаан хоолой уртасч, тахиралдана. Улаан хоолойн төгсгөлийн хэсэг тогтмол нарийсна. Ходоодны хийн бөмбөлөг байхгүй. Эзофагит, перизофагитаар хүндэрнэ. Ацетилхолины сорил (-)

/155./ Уйланхай-зангилаа дүрслэлээр ховор илрэх эмгэгүүд ?

1. нейроцитом

2. гамартом

3. гүүрний глиом

4. глиобластом
5. гемангиобластом

/156./ Бүдүүн гэдэсний меланоз ихэвчлэн хаана байрладаг вэ ?

1. шулуун гэдсэнд
2. өгсөх гэдсэнд
3. хөндлөн гэдсэнд
4. мухар гэдсэнд
5. уруудах гэдсэнд

/157./ Титэм судасны КТ ангиографийн Volume Rendering дүрслэлийн ач холбогдлыг тодорхойлно уу ?

1. сонгодог хавтгайд титэм судас уртын хэмжээгээр дүрслэгдэх
2. титэм судасны гурван хэмжээст дүрслэл тод харагдах
3. шохойжилт илэрхий харагдах
4. титэм судас дүрсийн давхцалгүй дүрслэгдэх
5. эмнэлзүйн ач холбогдол бүхий товруу тод харагдах

/158./ Дисплази гэсэн ойлголтонд ямар өөрчлөлтүүд орох вэ ?

1. эсийн атипид
2. эдийн бүтцийн алдагдал
3. ялгарал алдагдах
4. улайлт гастрит
5. өнгөц гастрит

/159./ Ангиографийн шинжилгээний явцад цочмог тромбэмболи үүссэн тохиолдолд ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ ?

1. яаралтай эндартериэктоми мэс засал хийх
2. механик аспираци (соруулах) хийх
3. ангиопластик ажилбар хийх
4. урокиназа ферментээр тромболиз эмчилгээ хийх
5. ампутаци хийх

/160./ Өвдөгний үе болон арын чагтан холбоосны урагдлыг оновчтой оношлох шинжилгээний аргуудыг нэрлэнэ үү?

1. КТ
2. үений СРТ
3. ангиографи
4. артроскопи
5. фистулографи

/161./ Уйланхай-зангилаа дүрслэлээр түгээмэл илрэх эмгэгүүд ?

1. гемангиобластом
2. ганглиоглиом
3. краниофарингиом
4. полициитар астроцитом
5. нейрофибром

/162./ Титэм судасны КТ ангиографийн MIP дүрслэлийн ач холбогдлыг тодорхойлно уу ?

1. сонгодог хавтгайд титэм судас уртын хэмжээгээр дүрслэгдэх
2. титэм судасны сегмент тус бүрийг үнэлэх боломжтой
3. титэм судсан дахь жижиг шохойжилт нарийн харагдах
4. судасны нарийсалт, шохойжилтыг үнэлэх
5. титэм судасны эргэлт, тахиралдалт, мурийлт тод дүрслэгдэх

/163./ Судас бөглөх эмчилгээг ямар хэлбэрүүдэд ангилж үзэх вэ ?

1. гол салаа судсыг бөглөх
2. үндсэн артери, түүний салаа судсыг бөглөх
3. хэсэг газрын тэжээгч судсыг бөглөх
4. стент тавих
5. нарийслыг тэлэх

/164./ Тодосгогчтой КТ шинжилгээнд нэг төрлийн тодосгогч бодисын шингээлт болон тодрол бүхий бүдүүн гэдэсний ханын зузаарлын өөрчлөлтөөр зонхилон илэрдэг эмгэгүүдийг нэрлэнэ үү ?

1. субмукозын доорх цус хуралт
  2. лимфом
  3. аденокарцином
  4. архаг Крон өвчин
  5. туяа эмчилгээний нөлөөт бүдүүн гэдэсний үрэвсэл
- /165./ Элэгний хавдрын тэжээгч судасыг бөглөх эмчилгээний эсрэг заалт юу вэ ?
1. элэгний хатуурлын суурин дээр үүссэн хавдартай, элэгний хатуурлын “С” зэрэглэлтэй
  2. элэгний үйл ажиллагааны алдагдалтай, ээнэгшлээ алдсан, хэвлийд сул шингэнтэй, хавдрын хордлого илэрсэн
  3. цусан дахь альбумины хэмжээ буурсан, билирубины хэмжээ 3,0-оос дээш, цэс зогсонгошилтой
  4. улаан хоолой венийн судсанд 3-4 багана судас өргөссөн үе
  5. цэсний хүүдий чулуутай
- /166./ Төвийн нейроцитомын олонтоо тохиолддог байрлалууд ?
1. Монро нүхэнд ойрхон хажуугийн ховдлын хэсэгт
  2. форниксд
  3. тунгалаг таславчинд
  4. 4-р ховдолд
  5. 3- ховдолд
- /167./ Ангиографийн шинжилгээнд голлон ашигладаг тодосгогч бодисуудыг нэрлэнэ үү ?
1. урографин
  2. ультравист
  3. омниopak
  4. верографин
  5. гадовист
- /168./ Протон-нягтралаар жинлэгдсэн дараалалыг (proton-density weighted) тодорхойлоход аль нь тохирч байна вэ ?
1. богино цуурайн (TE) хугацаа
  2. урт дахилтын (TR) хугацаа
  3. завсрын жинлэгдсэн дараалал
  4. Gradient-echo
  5. FLAIR
- /169./ Каверномын СРТ-ийн шинж тэмдгүүдээс ?
1. T2-жинлэгдсэн дараалалд тод бараан хүрээтэй
  2. зах ихмэг тод
  3. төв хэсэгтээ холимог дохионы эрчимтэй
  4. эргэн тойрны тархины зөөлөн эдэд их хэмжээний хавантай
  5. тодрол сайтай
- /170./ Салст бүрхүүлийн хавдрын урьдал өөрчлөлтүүд
1. эсийн хувирал
  2. салст бүрхүүлийн хүнд зэргийн дисплази
  3. салст бүрхүүлийн гиперплази
  4. салст бүрхүүлийн хатингаршил
  5. салст бүрхүүлийн бага зэргийн дисплази
- /171./ КТ шинжилгээгээр бүдүүн гэдэсний ханын өөрчлөлтийг ямар шинжүүдээр үнэлэх вэ ?
1. бүдүүн гэдэсний ханын зузаарлын зэрэг
  2. бүдүүн гэдэсний хана тэгш хэмтэй болон тэгш хэмтэй бус байдлаар зузаарах
  3. бүдүүн гэдэсний ханын тодосгогч бодисын шингээлт болон тодролын байдал
  4. бүдүүн гэдэсний ханын зузаарлын үргэлжлэх уртын байдал
  5. гэдэсний ойролцоох эмгэг өөрчлөлттэй хавсарсан эсэх
- /172./ Иод агуулсан тодосгогч бодисыг хүний биед тарих үед үүсэх харшлын хариу урвалыг Анселлагийн шалгуураар хэрхэн ангилах вэ ?
1. сул урвал
  2. дунд зэргийн урвал
  3. хүчтэй урвал
  4. хэт их хүчтэй урвал

5. дээрх бүгд буруу

/173./ Алцгеймерийн өвчний СРТ-ийн шинж тэмдгүүдээс ?

1. үйл ажиллагааны шинжилгээнүүдэд анхдагч сенсоромотор төвүүдийн перфузи эрт үед буурах

2. зулай болон чамархайн дэлбэнгүүдэд хатингаршил давамгайлах

3. дух болон чамархайн дэлбэнгүүдэд хатингаршил давамгайлах

4. үйл ажиллагааны шинжилгээнүүдэд анхдагч арын сингулат, зулай-чамархайн хэсгүүдийн перфузи эрт үед буурах

5. ламинар некроз ажиглагдах

/174./ Судас бөглөх эмчилгээнд ашиглаж байгаа материалуудыг хэрхэн ангилах вэ ?

1. биологийн (цусны бүлэн, фибрины ялтас, цусны өтгөрсөн сийвэн гэх мэт)

2. синтетик (гельфоам, спонгель, липиодол, полистерол)

3. органик (воск, идэвхжүүлсэн нүүрс)

4. неорганик (нитинол)

5. бусад

/175./ Крон өвчний нэвчдэсийн үеийн эндоскопийн шинж тэмдгээс ?

1. хүрэлцэхэд бага зэргийн цус шүүрэлттэй

2. өнгөц шархлаанууд

3. салстын хаван

4. салстын доод давхаргын хаван

5. судасны зураглал олширсон

/176./ Ангиографи шинжилгээний оношилгоо-эмчилгээний үндсэн чиглэл юу вэ ?

1. эрхтэн системийн эмгэгийг оношлох

2. сэтгүүрийг ашиглаж эмээр эмчлэх

3. судсан дотуур мэс заслын аргаар эмчлэх

4. судас залгах

5. хими эмчилгээ хийх

/177./ Бөөрний тодосгогч бодистой КТ шинжилгээний үе шатуудыг сонгоно уу ?

1. кортикомедуляр үе шат

2. нефрографик үе шат

3. ялгарлын үе шат

4. эдийн шингээлтийн үе шат

5. давхар тодосгогчийн үе шат

/178./ Гол судасны диссекцийг (цууралт) Де Баккейн ангилалаар хэрхэн ангилах вэ ?

1. I хэлбэр

2. II хэлбэр

3. III хэлбэр

4. IV хэлбэр

5. V хэлбэр

/179./ Эпидураль цус хуралтаар хүндрэх эмгэгүүдийг сонгоно уу ?

1. цус хомсрох

2. гэмтэл

3. АВМ

4. хатуу бүрхүүлийн артери-венийн фистул

5. артерийн судасны цүлхэн

/180./ Уушиг зүрхний хам шинж нь эгц байрлалын зүрх судасны сүүдрийн ямар ямар нумуудын өөрчлөлтөөр илрэх вэ?

1. Баруун тосгуурын нум уртсах

2. ЗСС-ийн зүүн талын 2-р нум уртсах

3. Баруун талын судас тосгуурын өнцөг дээшлэх

4. Гол судасны өгсөх хэсгийн нум уртсах

5. Зүрхний бэлхүүс хотойх

/181./ Цочмог эпидурал цус хуралт нь тодосгогчгүй КТ-ийн шинжилгээнд ямар шинжүүдээр дүрслэгдэх вэ ?

1. гиперденс масс

2. эктра-аксиал гиперденс масс

3. хоёр тал руугаа гүдгэр хэлбэртэй дүрслэгдэх
  4. цус хуралт эпидурал зайд байрлах
  5. цус хуралт нь субарахнойд зайд байрлах
- /182./ Титэм судасны КТ ангиографийн MIP дүрслэлийн ач холбогдлыг тодорхойлно уу ?
1. сонгодог хавтгайд титэм судас уртын хэмжээгээр дүрслэгдэх
  2. титэм судасны сегмент тус бүрийг үнэлэх боломжтой
  3. титэм судсан дах жижиг шохойжилт нарийн харагдах
  4. судасны нарийсалт, шохойжилтыг үнэлэх
  5. титэм судасны эргэлт, тахиралдалт, мурийлт тод дүрслэгдэх
- /183./ Хавдрын урьдал өөрчлөлтөнд ямар эмгэгүүд орохгүй вэ ?
1. метаплази
  2. дисплази I зэрэг
  3. дисплази II зэрэг
  4. дисплази III зэрэг
  5. даамжирах дисплази
- /184./ Өвөрмөц бус шархлаат колитын идэвхижлийн бага зэргийн эндоскопийн шинж тэмдгээс ?
1. хүрэлцэхэд бага зэргийн цус шүүрэлттэй
  2. салст бүрхүүлийн хаван
  3. өнгөц шархлаанууд
  4. салстын доод давхаргын хаван
  5. судасны зураглал олширсон
- /185./ Тодосгогч бодис хэрэглэхэд харшлах хүчин зүйл юу вэ ?
1. элэг, бөөрний өвчний хүнд хэлбэр
  2. зүрхний өвчний хүнд хэлбэр
  3. хүнд хэлбэрийн Базедовын өвчин
  4. тодосгогч бодисын харшилтай хүнд
  5. өндөр халуунтай, халдварт өвчтэй хүнд
- /186./ Зүрхний булчингийн эсэд Mc-99m Sestamibi ямар механизмаар зөөвөрлөгдөх вэ ?
- A. цитозолик уурагтай нэгдэхгүй
  - B. мембранд нэвчихгүй
  - C. цитозолик уурагтай нэгдэх
  - D. мембранд нэвчих
  - E. идэвхитэй зөөвөрлөгдөх
- /187./ Түнхний төрөлхийн мултралын үед илрэх рентген онцлог шинж тэмдгийн нэр ?
- A. Отто-хробакын шинж тэмдэг
  - B. Марфаны шинж тэмдэг
  - C. Мейсснерийн шинж тэмдэг
  - D. Майкова-Строгановын шинж тэмдэг
  - E. Белерийн шинж тэмдэг
- /188./ Хэт авиан шинжилгээгээр жирэмсний эхний 3 сарын төгсгөлөөр ихэсийн бүтэц ямар байх вэ ?
- A. хэт авиан бүтцээс бүрэн чөлөөлөгдсөн
  - B. олон тооны жижиг мөхлөгөн дотор бүтэцтэй
  - C. тасралтгүй шугаман хэт авиан бүтэцтэй
  - D. хагас саран хэлбэртэй
  - E. хавтгай цүлхийсэн хэлбэртэй
- /189./ Нэвчдэст сүрьеэгийн рентген шинж тэмдгээс ?
- A. уушгины дээд дэлбэнгийн арын сегментэд голдуу байрласан, 1 см-ээс том хэмжээний, дугариг эсвэл зөв биш хэлбэрийн, нэг тооны, бүтэц нэг төрлийн, нягтрал ихэссэн, зах хязгаар тод-жигд бус сүүдэржилт тодрох
  - B. уушгины I, II, VI сегментэд байрласан, дугариг эсвэл зөв биш хэлбэрийн, 1.5 см-ээс их хэмжээний, бүтэц нэг төрлийн бус, нягтрал жигд бус ихэссэн, зах хязгаар тод-жигд, сүүдэржилт тодорч, эргэн тойрон голомтуудтай байх

С. уушгины III, IV, V сегментэд байрласан, зөв биш хэлбэрийн, янз бүрийн хэмжээний, нэг тооны, бүтэц нэг төрлийн, нягтрал ихэссэн, зах хязгаар тод-долгионтсон сүүдэржилт тодорч, эргэн тойрны уушгины эдэд уушгины зураглалын хэлбэр алдагдах

D. уушгинд дугариг хэлбэрийн, янз бүрийн хэмжээний, нэг тооны, бүтэц нэг төрлийн, нягтрал ихэссэн, зах хязгаар тод-жигд сүүдэржилт тодрох

E. уушгинд дугариг хэлбэрийн, янз бүрийн хэмжээний, нэг тооны, бүтэц нэг төрлийн, нягтрал ихэссэн, зах хязгаар тод-жигд сүүдэржилт тодорч, гүнзгий амьсгаа авахад хэлбэр нь өөрчлөгдөх

/190./ Уушгины артерийн тромбозомболийн үед перфузийн сцинтиграммд ямар шинж илэрдэг вэ ?

A. халуун голомт илрэх

B. шингээлт жигд бус болох

C. уушгины дэлбэн, сегментийн анатомийн бүтэцтэй тохирсон цусан хангамжийн өөрчлөлт гарах

D. хүйтэн голомт илрэх

E. идэвхитэй зөөвөрлөгдөх

/191./ Ургийн ахар сүүл-зулайн хэмжээг хэдэн долоо хоногтойд хэмжих вэ ?

A. 7-11 долоо хоногтойд

B. 4-6 долоо хоногтойд

C. 12 –с дээш долоо хоногтойд

D. 16-20 долоо хоногтойд

E. 22-26 долоо хоногтойд

/192./ Цочмог пиелонефритын хэт авиан онцлог шинжээс ?

A. бөөр томорч, хөндлөнгөөрөө өргөсч, хэт авиан цуурайжилтгүй, тод хил хязгаартай голомтот үүсгэвэр төв хэсгээр байрлаж, бөөрний цуллаг нимгэрч, бөөрний хоёр туйл хадгалагдан үлдэх

B. бөөр багасч, хөдөлгөөн хязгаарлагдмал болох

C. бөөр томорч, аяганцар-тэвшинцэр өргөсч, бөөрний хөдөлгөөн хязгаарлагдмал болох

D. бөөрний хөдөлгөөн хязгаарлагдаж, эргэн тойрны эдийн хооронд шингэн хуримтлагдах

E. бөөрний аяганцар-тэвшинцэр таслагдах

/193./ КТ-р нойр булчирхайн цочмог үрэвслийн Бальтазарын ангилалаар D зэрэг ямар байх вэ ?

A. нойр булчирхай хэсэг газараа эсвэл тархмал томорсон, хил хязгаар тод-жигд бус, бүтцийн ижил төрөлшил алдагдсан, холимог нягтралтай, нойр булчирхайн эргэн тойрны өөхлөгт үрэвслийн өөрчлөлтгүй

B. нойр булчирхайн цуллагт том биш, ихэнхидээ ганц шингэн агуулсан хэсэг тодорч, хил хязгаар тод бус байна.

C. нойр булчирхайн цуллагт 2 болон түүнээс олон тооны, том хэмжээний шингэн агуулсан хэсэг тодорч, нойр булчирхайн цуллаг эсвэл хэвлийн арын зайнд хийн бөмбөлөг тодорно.

D. нойр булчирхайн цуллагт өөрчлөлттэй, нойр булчирхайн эргэн тойрны өөхлөгт үрэвслийн өөрчлөлттэй

E. нойр булчирхай өөрчлөлтгүй

/194./ Лимфгранулематозын хэт авиан онцлог шинж тэмдгээс ?

A. дэлүү томорч, дэлүүний үүдэн вен өргөсөх

B. дэлүүнд нягтрал ихэссэн голомтот үүсэвэр тодрох

C. дэлүү томрохын зэрэгцээ, лимфийн булчирхай томрох

D. дэлүү томорч, дэлүүний хэт авиан нягтрал өөрчлөгдөхгүй

E. дэлүү томорч, бүтцийн ижил төрөлшилтэй, нягтрал ихсэх

/195./ Уушгины бронх дагуух хавдрын III-р фазын рентген онцлог шинжээс ?

A. дэлбэн эсвэл сегментийн уушгины зураглалд олширох

B. бронхын хана зузаарч, уушгины зураглал өтгөрч, олширох

C. бронхын хана зузаарч, дэлбэн эсвэл сегментийн агааржилт буурах

D. бронхын хана зузаарч, дэлбэн эсвэл сегментийн эзлэхүүн багасах

E. бронхын хана зузаарч, уушгины угаас уушгины зураглал өргөсч, татлага хэлбэртэй болох

/196./ Цэлмэнлэг хавдар нь ихэвчилэн бүдүүн гэдэсний хаана байрладаг вэ ?



- A. уруудах гэдсэнд
- B. хөндлөн гэдсэнд
- C. өгсөх гэдсэнд
- D. шулуун гэдсэнд
- E. мухар гэдсэнд

/197./ Хамрын хөндийн дайврын полипын рентген онцлог шинж тэмдгээс

A. дугариг, зууван хэлбэрийн, хил хязгаар тод тэгш, бүтэц нэг төрлийн, нягтрал ихэссэн голомтот болон үүсгэвэр өөрчлөлт тодрох

B. хагас дугариг хэлбэрийн, хил хязгаар тод тэгш бус, бүтэц нэг төрлийн, нягтрал ихэссэн голомтот болон үүсгэвэр өөрчлөлт тодрох

C. үрэвслийн эсрэг эмчлгээний дараа хэмжээ багасах

D. зөв биш хэлбэрийн, хил хязгаар тод тэгш бус, бүтэц нэг төрлийн нягтрал ихэссэн голомтот болон үүсгэвэр өөрчлөлт тодрох

E. дугариг, зууван хэлбэрийн, хил хязгаар тод тэгш бус, бүтэц нэг төрлийн, нягтрал ихэссэн голомтот болон үүсгэвэр өөрчлөлт тодрох

/198./ Легга-Кальве-Пертес өвчний импрессион хугарлын үе шатны рентген онцлог шинж тэмдгээс ?

A. остеонекрозын зон үүсэх

B. ясны үхжсэн хэсэг шимэгдэж, шинэ ясны балок үүсэх

C. яс гэмтсэн хэсгийн сүүдэржилт жигд эсвэл жигд бус ихсэж, яс хатуурч, үений зай өргөсөх

D. уйланхай маягийн хөндий үүсэх

E. хэлбэр алдагдсан артроз үүсэх

/199./ Бамбай булчирхайн аденомын үед илрэх хэт авиан онцлог шинж тэмдгээс ?

A. “шанаган хорхойн сүүл” шинж тэмдэг

B. “хало” шинж тэмдэг

C. “давхарласан бялуу” шинж тэмдэг

D. “үхрийн нүд” шинж тэмдэг

E. цасан шамарга” шинж тэмдэг

/200./ Хоёр уушгийг хамарсан цайваржилт өгдөг зүрхний гаралтай ямар өвчин байдаг вэ ?

A. артерийн битүүрээгүй цорго

B. зүрхний тосгуур хоорондын таславчийн цоорхой

C. тетрад Фалло

D. зүрхний ховдол хоорондын таславчийн цоорхой

E. уушгины эмфизем

### **Сорилын зөв хариулт-Сорил-1**

1-C, 2-D, 3-A, 4-A, 5-A, 6-C, 7-A, 8-B, 9-A, 10-E, 11-E, 12-D, 13-D, 14-E, 15-B, 16-A, 17-A, 18-E, 19-E, 20-E, 21-D, 22-A, 23-B, 24-D, 25-E, 26-B, 27-C, 28-B, 29-D, 30-E, 31-A, 32-C, 33-C, 34-C, 35-E, 36-C, 37-C, 38-C, 39-E, 40-D, 41-A, 42-D, 43-C, 44-A, 45-E, 46-E, 47-D, 48-C, 49-E, 50-C, 51-D, 52-D, 53-A, 54-A, 55-C, 56-C, 57-C, 58-D, 59-C, 60-C, 61-E, 62-A, 63-E, 64-C, 65-A, 66-C, 67-A, 68-B, 69-B, 70-D, 71-D, 72-C, 73-B, 74-C, 75-D, 76-D, 77-A, 78-E, 79-B, 80-E, 81-D, 82-A, 83-E, 84-D, 85-A, 86-E, 87-C, 88-C, 89-C, 90-E, 91-C, 92-D, 93-C, 94-D, 95-E, 96-C, 97-C, 98-A, 99-C, 100-D, 101-D, 102-A, 103-C, 104-E, 105-E, 106-C, 107-D, 108-D, 109-C, 110-D, 111-C, 112-B, 113-C, 114-E, 115-A, 116-B, 117-C, 118-B, 119-B, 120-B, 121-D, 122-D, 123-D, 124-C, 125-A, 126-C, 127-D, 128-B, 129-A, 130-D, 131-C, 132-C, 133-B, 134-B, 135-A, 136-C, 137-A, 138-D, 139-C, 140-E, 141-C, 142-A, 143-D, 144-C, 145-E, 146-A, 147-E, 148-A, 149-E, 150-A, 151-D, 152-E, 153-D, 154-D, 155-B, 156-C, 157-C, 158-A, 159-C, 160-C, 161-B, 162-B, 163-A, 164-A, 165-B, 166-A, 167-B, 168-A, 169-A, 170-B, 171-E, 172-A, 173-C, 174-B, 175-C, 176-A, 177-A, 178-A, 179-C, 180-A, 181-B, 182-B, 183-B, 184-C, 185-E, 186-D, 187-D, 188-B, 189-A, 190-C, 191-A, 192-C, 193-B, 194-C, 195-B, 196-D, 197-A, 198-C, 199-B, 200-C,


## Сорил-2

### Тохиолдол 1

Өвчтөн Б. 16 настай, эрэгтэй. Сагсан бөмбөг тоглож байгаад шанаа руугаа хүчтэй цохиулж ухаангүй болсон. 10 орчим минутын дараа ухаан орж, эмнэлэгт хүргэгдсэн.

**Бодит үзлэгт:** хүүхэн хараа 2 талдаа ижил бус, гавлын дотрох цус алдалт гэж сэжиглэн толгойн компьютерт томографийн шинжилгээ хийсэн.

**Компьютерт томографийн зураг:**



#### 1. Оношийг тавина уу?

- A. Тархины цус харвалт
- B. Эпидураль гематома/ экстра-аксиаль гематома
- C. Менингиома
- D. Субдураль гематома/ интра-аксиаль гематома
- E. Шваннома

#### 2. Тархины интра-аксиаль хавдруудыг нэрлэ ?

- 1. Менингиома
- 2. Астроцитома
- 3. Хондросаркома
- 4. Эпендимома
- 5. Метастаз

#### 3. Субдураль гематома/интра-аксиаль гематомын компьютерт томографид илрэх шинжүүдийг нэрлэнэ үү ?

- 1. Гүдгэр линзний хэлбэртэй
- 2. Хавирган сар хэлбэртэй
- 3. Хэсэг газрыг хамарсан
- 4. Их талбайг хамарсан
- 5. Дугуй хэлбэртэй

#### 4. Эпидураль гематома/ экстра-аксиаль гематома үүсгэх үндсэн шалтгааныг нэрлэ ?

- 1. Тархины гэмтэл
- 2. Зөөлөн хальсны судасны мальформац
- 3. Гавал ясандах хавдрын үсэрхийлэл
- 4. Тархины буглаа
- 5. Тархины хавдар

#### 5. Оношийг батлах зорилгоор ямар нэмэлт шинжилгээнүүдийг хийж болох вэ?

- A. Толгойн эгц болон хажуу рентген зураг авах
- B. Тархины судасны ангиографи

- C. Соронзон резонанст томографи
- D. Тархины судасны доплерографи
- E. ЭЭГ

1	2	3	4	5
B	C	C	A	C


### Тохиолдол 2

Өвчтөн. Н. 68 настай, эрэгтэй турна, ядарч сульдана, хэвлийгээр өвдөнө, өтгөн хатна, цустай гарна гэсэн зовиуртай эмнэлэгт хандсан.

**Бодит үзлэгт:** хэвлийн зүүн доод талбайд эмзэглэлтэй, том хэмжээний үүсгэвэр тэмтрэгдэнэ, цус багадалтын шинжүүд илэрнэ.

**Лабораторийн шинжилгээнд:** ЦЕШ-Hb-76 анеми, СЕА-1107

**Ирригограмм:**



### 1. Энэ шинжилгээнд ямар өөрчлөлт илэрсэн бэ?

1. Бүдүүн гэдэсний гауструуд арилсан
2. Бүдүүн гэдэсний уруудах хэсэгт
3. Долихо сигма
4. Алимны голны шинж
5. Дефект

### 2. Ирригоскопийн шинжилгээнд ямар тодосгогч бодис хэрэглэдэг вэ?

1. Иодын усан уусмалууд
2. Агаар/хий
3. Иодын тосон уусмал
4. BaSO<sub>4</sub>
5. Липиодол

### 3. Оношийг тавина уу?

- A. Бүдүүн гэдэсний полип
- B. Бүдүүн гэдэсний дивертикул
- C. Бүдүүн гэдэсний хавдар
- D. Бүдүүн гэдэсний гаж хөгжил
- E. Шулуун гэдэсний ивэрхий

### 4. Онош батлах зорилгоор нэмэлт ямар шинжилгээг төлөвлөх вэ ?

1. Хэвлийн хөндийн тодосгогчтой компьютерт томография
2. Бүдүүн гэдэсний дуран
3. Биопси
4. Хэвлийн хэт авиан шинжилгээ
5. Сцинтиграфи

### 5. Бүдүүн гэдэсний хавдрын үед ирригоскопийн шинжилгээнд илэрч болон рентген шинжүүдийг нэрлэ ?

1. Бөгжилсөн хэлбэр
2. Хоолой хэлбэр
3. Шархлаа төст хэлбэр
4. Цэцэгт байцаа хэлбэр
5. Дээрх бүгд


1	2	3	4	5
C	C	C	A	E

### Тохиолдол 3

Өвчтөн. Д. 57 настай, эрэгтэй. Нуруугаар үе үе өвдөнө, өвдөлт гуяны ар талаар дамжина гэсэн зовиуртай мэдрэлийн эмчид хандав.

**Бодит үзлэгт:** нуруу бөхийж, нурууны булчин чангарсан, Ласегийн шинж эерэг.

**Бүсэлхийн нурууны соронзон резонанст томографийн зураг:**



#### 1. Онош тавина уу?

1. Бүсэлхийн нурууны L4/5 дискний ивэрхий
2. Бүсэлхийн нурууны L4/5-ын спондилез
3. Бүсэлхийн нурууны L4/5-ын остеохондроз
4. Бүсэлхийн нурууны L4/5, L5/S1 дискний ивэрхий
5. Бүсэлхийн нурууны L4/5-ын спондилит

#### 2. Нурууны эзэлхүүнт үүсгэвэрүүдийг байрлалаар нь хэрхэн ангилах вэ ?

1. Экструдураль
2. Интрадураль/экстремедулар
3. Интрамедулар
4. Экструдураль/интрамедулар
5. Бүгд зөв

#### 3. Экструдураль байрлалтай тодорхойлогддог эмгэгүүдийг нэрлэ?

1. Менингиома
2. Нугаламын гемангиома
3. Астроцитома
4. Эпидураль буглаа
5. Бүгд зөв

#### 4. Ихэвчлэн интрамедулар байрлалтай тодорхойлогддог эмгэгүүдийг нэрлэ ?

1. Мелит
2. Гемангиобластома
3. Астроцитома
4. Эпидураль гематом
5. Бүгд зөв

#### 5. Бүсэлхийн нурууны дискний ивэрхий аль түвшинд илүү тохиолддог вэ ?


- A. L1/L2
- B. L5/S1

- C. Th12/L1
- D. L4/L5
- E. L3/L4

1	2	3	4	5
D	A	C	A	B

#### Тохиолдол 4

Өвчтөн Ч. 44 настай. Эрэгтэй. Байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдан цээжний рентген зураг авахуулахад баруун талын уушгины талбайн дунд 1/3-т байрласан дугуй хэлбэрийн, зах ирмэг нь барзгар, дотроо шохойжсон голомттой, нэгэн төрлийн бус бүтэцтэй үүсгэвэр тодорхойлогдоно. Баруун талын синус хаалттай байв. Дээрх шинжүүд дээр тулгуурлан эмч уушгины хавдар байх магадлалтай гэж дүгнэв.



#### 1. Уушгины хавдрын олон улсын ангилалыг нэрлэнэ үү?

1. Гуурсан хоолойн карцинома
2. Уушгины саркома буюу уушгины бусад анхдагч хавдрууд
3. Уушгины хоргүй хавдар
4. Тунгалагийн замын хортой ба хоргүй эмгэгшил
5. Үсэрхийлсэн хавдар

#### 2. Уушгины хавдар үүсгэх эрсдэлт хүчин зүйлсийг нэрлэнэ үү?

1. Тамхидалт
2. Идэвхгүй тамхидалт
3. Асбестоз
4. Туяа эмчилгээ
5. Таргалалт

#### 3. Уушгины хавдрыг илрүүлэхэд ашигладаг дүрс оношлогооны багажийн шинжилгээний аргуудыг нэрлэнэ үү?

1. Цээжний рентген шинжилгээ
2. Компьютерт томографи
3. Соронзон резонанст томографи
4. Дуран
5. Биопси

#### 4. Дүрс оношлогооны шинжилгээгээр илрэх шинжээр нь гуурсан хоолойн карцинома хавдрыг хэрхэн ангилж болох вэ?

1. Захын байрлалтай хавдар
2. Төвийн байрлалтай хавдар
3. Цээжний хөндийд тархаж байрласан хавдар
4. Нэвчсэн хавдар
5. Үсэрхийлсэн хавдар

#### 5. ДЭМБ-ийн ангилалын дагуу гуурсан хоолойн карцинома хавдрыг ямар эсүүд үүсгэдэг вэ?

1. Булчирхайлаг эст карцинома
2. Хавтгай хучуур эст карцинома
3. Том эст карцинома

4. Жижиг эст карцинома
5. Өвөрмөц эст карцинома

**6. Уушгины хавдрыг үнэлэх дүрс оношлогооны шинжүүдийг нэрлэнэ үү?**

1. Хавдрын хэлбэр
2. Хавдрын зах ирмэг
3. Хөндийтэй эсэх
4. Шохойжсон голомттой эсэх
5. Уг өргөссөн эсэх

**7. Хавдрын олон улсын TNM ангилалын дагуу уушгины хавдар T2 ангилалд ямар хэмжээтэй байх вэ?**

- A. 2 см >
- B. 2 см <
- C. 3 см <
- D. 3 см >
- E. Хэмжээ хамаарахгүй

**8. Хавдрын олон улсын TNM ангилалын дагуу уушгины хавдар T1 ангилалд ямар хэмжээтэй байх вэ?**

- A. 2 см >
- B. 2 см <
- C. 3 см <
- D. 3 см >
- E. Хэмжээ хамаарахгүй



**9. Уушгины анхдагч хавдрын төлөөлөгчдийг нэрлэнэ үү?**

1. Фибросаркома
2. Лейомиосаркома
3. Хондросаркома
4. Фибролейомиосаркома
5. Рабдомиосаркома

1	2	3	4	5	6	7	8	9
E	B	B	A	B	E	D	C	E

## Тохиолдол 5

Өвчтөн Я . 55 настай. Эрэгтэй. Дөрвөн жилийн өмнөөс цээж орчмоор нь өвдөх болсон. Даралт тогтмол өндөр байдаг. Чихрийн шижин оношлогдоод 10 жил болж байгаа. Өнөөдөр өглөө ажилд явж байхад нь цээжээр нь гэнэт хүчтэй хатгуулан өвдсөн тул шууд эмнэлэг рүү хүрч ирсэн. Эмч яаралтай цээжний хөндийн рентген шинжилгээ хийхийг зөвлөв.



**1. Зүрх-том судасны рентген шинжилгээг хийхдээ шинжлүүлэгчийг ямар байрлалуудад зогсоож хийх вэ?**

1. Эгц урд байрлал
2. Баруун урд буюу 1-р ташуу байрлал
3. Зүүн урд буюу 2-р ташуу байрлал
4. Зүүн хажуу байрлал
5. Арын байрлал

**2. Шинжлүүлэгчийн гарыг ташаанд тавиулж, тохойг урагш болгон, өвчүүг дунд шугаманд, өөрөөр хэлбэл хоёр эгэмний өвчүү талын төгсгөлийг өвчүүний 2 талд ижил байрлуулж зүрх-том судасны рентген шинжилгээг хийсэн бол аль байрлалаар авсан зураг бэ?**

- A. Эгц урд байрлал
- B. Баруун урд буюу 1-р ташуу байрлал
- C. Зүүн урд буюу 2-р ташуу байрлал
- D. Зүүн буюу баруун хажуу байрлал
- E. Арын байрлал Иодын тосон уусмал

**3. Шинжлүүлэгчийн баруун мөрийг дэлгэцэнд ойртуулж, зүүн мөрийг дэлгэцнээс холдуулж, дэлгэцийн хавтгай, биеийн фронтал хавтгайн хооронд 45-50 градус өнцөг үүсгэж зүрх - том судасны рентген шинжилгээг хийсэн бол аль байрлалын авсан зураг бэ?**

- A. Эгц урд байрлал
- B. 1-р ташуу байрлал
- C. 2-р ташуу байрлал
- D. Зүүн буюу баруун хажуу байрлал
- E. Арын байрлал

**4. Шинжлүүлэгчийн зүүн мөрийг дэлгэцэнд ойртуулж, зүүн мөрийг дэлгэцнээс холдуулж, дэлгэцийн хавтгай, биеийн фронтал хавтгайн хооронд 50-60 градус өнцөг үүсгэж зүрх - том судасны рентген шинжилгээг хийсэн бол аль байрлалаар авсан зураг бэ?**

- A. Эгц урд байрлал
- B. 1-р ташуу байрлал
- C. 2-р ташуу байрлал
- D. Зүүн буюу баруун хажуу байрлал
- E. Арын байрлал Иодын тосон уусмал

**5. Шинжлүүлэгчийн хоёр гарыг толгой дээр нь өргүүлж, тохой тохойгоос нь бариулж, рентген зураг авч, гол судасны өгсөх, уруудах хэсэг, нумыг сайтар дүрсэлж шинжилсэн бол зүрх - том судасны рентген шинжилгээний аль байрлалын зураг авсан бэ?**

- A. Эгц урд байрлал
- B. 1-р ташуу байрлал
- C. 2-р ташуу байрлал
- D. Зүүн хажуу байрлал
- E. Арын байрлал

1	2	3	4	5
B	A	B	C	D



## Тохиолдол 6

Өвчтөн А 48 настай, эрэгтэй. 14 хоногийн өмнөөс 38-39 хэм хүртэл халуурч, ханиалгаж эхэлсэн.

**Цусны шинжилгээнд:** лейкоцит  $10 \times 10^9$  г/л, УЭТХ 36мм /цаг

**Рентген зурганд:** Баруун талын уушгины доод дэлбэнд байрласан 6.0 см голчтой, жигд биш зузаан ханатай, дотроо шингэний түвшин бүхий цагариг төст сүүдэр дүрслэгдэнэ.

**Рентген зурганд:**



### 1. Оношийг тавина уу?

- A. Уушгины поликистоз
- B. Уушгины хавдар
- C. Хөндийт сүрьеэ
- D. Уушгины буглаа
- E. Уушгины бэтгийн хөндий

### 2. Цагираг төст сүүдрийн уушгины гаралтай эсэхийг хэрхэн үнэлэх вэ?

- 1. Цагираг төст сүүдэр нь цээжний хананд их сууриар наалдаж байрласан
- 2. Цагираг төст сүүдэр нь хавирганы сүүдэртэй холбоотой
- 3. Дээш өргөгдсөн өрцний дор цагираг төст сүүдэр дүрслэгдэнэ.
- 4. Цагираг төст сүүдэр нь бүх талаараа уушгины эдээр хүрээлэгдсэн
- 5. Цагираг төст сүүдэр нь уушгины талбайн гадна хэсэгт байрласан

### 3. Нимгэн ханатай цагираг төст сүүдрээр илэрдэг эмгэг өөрчлөлтүүдийг нэрлэ.

- 1. Уушгины буглаа
- 2. Поликистоз
- 3. Уушгины хавдар
- 4. Агаарт киста
- 5. Уушгины бэтэг

### 4. Зузаан ханатай цагираг төст сүүдрээр илэрдэг эмгэг өөрчлөлтийг нэрлэ.

- 1. Сүрьеэгийн шинэ каверн
- 2. Захын байрлалтай уушигны өмөнгийн задрал
- 3. Уушгины буглаа
- 4. Агаарт киста
- 5. Бронхоэктэзы

### 5. Уушгины буглаа ба сүрьеэгийн каверн хоёрыг ялган оношлох рентген гол шинжийг нэрлэ.

- 1. Хөндийн голчийн хэмжээ
- 2. Хөндийн ханын зузаан нимгэн
- 3. Хөндийн тоо
- 4. Цагираг төст сүүдэр дэх шингэний түвшин
- 5. Сүрьеэгийн эсрэг эмчилгээ хийлгэж байсан эсэх

**6. Олон тооны, нимгэн ханатай, цагираг төст сүүдрээр илэрдэг эмгэг өөрчлөлтийг нэрлэ.**

1. Уушгины буглаа
2. Силикоз
3. Хөндийт сүрьеэ
4. Поликистоз
5. Уушгины хавдар

**7. Цагираг төст сүүдрээр илэрдэг эмгэгүүдийг ялган оношлох рентгений гол шинжийг нэрлэ.**

1. Цагираг төст сүүдрийн хөндийн ханын зузаан
2. Тоо, хэмжээ
3. Хөндийд шингэний түвшин байгаа эсэх
4. Цагираг төст сүүдрийн байрлал
5. Цагираг төст сүүдрийн хөндийн дундаж диаметр

<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>
<b>D</b>	<b>D</b>	<b>C</b>	<b>A</b>	<b>D</b>	<b>D</b>	<b>A</b>

## Тохиолдол 7

Өвчтөн А. 31 настай. Эмэгтэй. Дөрвөн жилийн өмнөөс аюулхай орчмоор нь өвдөх болсон. Өглөө ажилд явж байхад нь хэвлий рүү нь гэнэт нэвт, хүчтэй хатгуулан өвдөж, эмнэлэгт түргэнээр яаралтай хүргэгдэж ирсэн.

**Хэвлийн хөндийн тойм рентген харалтанд:** Баруун талын өрцний доор хадуур хэлбэрийн хий хуралдсан сүүдэр илэрсэн.

**Хэвлийн хөндийн тойм рентген зурганд:**



### 1. Оношийг тавина уу?

- A. Гэдэсний түгжрэл
- B. Ходоодны шархлаа
- C. Өрцний ивэрхий
- D. Ходоодны шарх цоорох
- E. Чацархайн артерийн тромбоз

### 2. Өрцний дор хий хуралдах шалтгааныг нэрлэ.

- 1. Давсаг цоорох
- 2. Хэвлийн хөндийг нээх мэс засал
- 3. Хэвлийн хөндийн хөндийт эрхтэн цоорох
- 4. Гэдэсний түгжрэл
- 5. Ходоодны үрэвсэл

### 3.Ходоодны шархлаа өвчний үед рентгенд илрэх шинжийг нэрлэ.

- 1. Симптом Ниша
- 2. Үрэвслийн хөвөө шинж
- 3. "Заагч хуруу" шинж
- 4. Чаши Клойбера
- 5. Гэдэсний гогцоо өргөсөх

### 4.Ходоодны шархлаа өвчнийг шинжлэх шинжилгээний аргуудыг нэрлэ.

- 1. Ирригоскопи
- 2. Рентгеноскопи, рентгенографи
- 3. Колоноскопи
- 4. Дурангийн шинжилгээ
- 5. Фистулографи

### 5.Хоол боловсруулах замын рентген шинжилгээнд ашигладаг тодосгогч бодисыг нэрлэ.

- 1. Иодын усан уусмал
- 2. Иодын тосон уусмал
- 3. Хийн тодосгогч
- 4. Барийн сульфатын усан уусмал
- 5. Хүчилтөрөгч

**6.Ходоодыг тодосгогч бодисын тусламжтайгаар харж шинжлэхэд ямар хэмжээний тодосгогч бодис ашиглах вэ?**

1. 1 мл/кг
2. 200 мл/кг
3. 0.7 мл/кг
4. 200 гр барийн сульфат
5. 400 гр барийн сульфат

**7.Тодосгогч бодисын тусламжтайгаар ходоодыг рентгенд харж шинжлэх дарааллыг нэрлэ.**

1. Ходоодны хийн байдал
2. Ходоодны салст бүрхэвч
3. Ходоодны хэлбэр, байрлал, тонус
4. Агшилт, сулралт, юүлэлтийн байдал
5. Булцуу хэсэг, дээд гэдэс

**8. Ходоодыг тодосгогч бодисоор хагас дүүргэж шинжлэхийн ач холбогдлыг нэрлэ.**

1. Ходоодны байрлал
2. Агшилт, сулралт, юүлэлтийн байдал
3. Ходоодны тонус
4. Ходоодны салст бүрхэвчийн байдал
5. Ходоодны хэлбэр гадаргууг үнэлнэ.

1	2	3	4	5	6	7	8
D	A	A	C	C	C	E	D